



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 5/1049


Улаанбаатар хот

Б.Оюунбилэгт буцалтгүй тэтгэмж
олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.7 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2.7 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Гаалийн төв лабораторийн шинжээч гаалийн улсын байцаагч Бадамсэрээжидийн Оюунбилэгийн хадам эх нас барсан тул нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгосугай.
2. Буцалтгүй тусламжид зарцуулах 420.000 (дөрвөн зуун хорин мянга) төгрөгийг зохих журмын дагуу гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Долгорсүрэн)-т зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Бат-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Р.ОТГОНЖАРГАЛ

1439501 3587